*Оюуны өмчийн газрын даргын 2020 оны*
*....  тоот албан бичгийн хавсралт*

# Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

# Оюуны өмчийн газар

# 2019 оны тайлан

| Д/д | Үйл ажиллагаа | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Нэг дэх үе шат ( 2017 - 2019) хүрэх түвшин , үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, | 1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | 2017 - 2022 | | Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх | Нийт 7 ХАСУМ гаргасан бөгөөд хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. (Нотлох баримт 1)<br><br>ХАСУМ хянасан дүгнэлтийг үндэслэн 6 албан хаагчийг албан тушаалд шинээр болон шилжүүлэн томилсон байх бөгөөд Оюуны өмчийн газрын даргын Б тушаалыг цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан байна. (Нотлох баримт 2)<br><br>Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1 этгээдийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан “олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” бий болох | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцлагыг дээшлүүлэх | | | | | үндэслэлтэй гэснийг үндэслэн тухайн албан тушаалд томилоогүй байна. | |
| 2 | | 5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | 2017 - 2022 | | Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх | 2019 оны тус газрын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн болон Оюуны өмчийн газрын даргын Б тушаалыг цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан байна.<br>(Нотлох баримт 2) | 100% |
| 3 | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, | 1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2022 | | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх | Төрийн албаны тухай хуульд /шинэчилсэн найруулга/ нийцүүлэн Албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн, 2019 оны 11 сард Төрийн албаны хурлаар орж буцсан бөгөөд албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулж байна.<br>Хүчин төгөлдөр үйлчилж байгаа албан тушаалын тодорхойлолтыг цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан.<br>(Нотлох баримт 3) | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | | | | | | |
| 4 | 4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | 1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2019 | | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх | Оюуны өмчийн газарт 2019 онд иргэд, байгууллагаас 384 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, 99.21%-тай шийдвэрлэсэн байна. Энд өргөдөл гомдлын 59.60%-ийг лавлагаа, мэдээлэл авах, 37.50%-ийг зөрчлийн тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл гомдол эзэлж байна. Оюуны өмчийн газрын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол хүлээн аваагүй байна. (Нотлох баримт 4)<br><br>Оюуны өмчийн газрын ёс зүйн хорооны ажиллах журам, Ёс зүйн хороо байгуулах тухай тушаалыг веб сайтад байршуулж ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. (Нотлох баримт 5)<br><br>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн аваагүй болно. | 100% |
| 5 | 4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл | 1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн | 2017 - 2022 | 0,236 | Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн | 1.Төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах, төсөв хөрөнгийг хэмнэх, төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа, хяналт, удирдлагын нэгдсэн систем буюу онлайн програм хангамжуудын сан бүхий вэб платформ Able системийг өдөр тутмын үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | дэд бүтцийг холбох | | | байх | ажиллагаандаа ашиглаж байна.<br>(Нотлох баримт 6, хуудасны тоо 2)<br>2. Санхүүгийн програм хангамжийн "Санхүүгийн Тооцоолох Групп" ХХК-тай гэрээ байгуулж, санхүүгийн бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>(Нотлох баримт 7, хуудасны тоо 7) | |
| 6 | 4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах | 2017 - 2019 | | Нийтийн албаны сургалтын институтийг байгуулсан байх | Оюуны өмчийн газрын орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг тогтоосон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/123 тоот тушаалын дагуу Мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан 1 мэргэжилтэн ажиллаж, иргэд аж ахуйн нэгж байгууллага руу чиглэсэн болон дотоод сургалтыг зохион байгуулдаг.<br>(Нотлох баримт 8, хуудасны тоо 2) | 100% |
| 7 | | 2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах | 2017 - 2019 | 122,6 | Модуль, хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулсан байх | 2019 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны төсөв батлуулж ажилласан болно. (Нотлох баримт 9, хуудасны тоо 4), биелэлтийг хангаж ажилласан. (Нотлох баримт 10, хуудасны тоо 20)<br>Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтанд давхардсан тоогоор нийт 6 албан хаагч хамрагдсан байна. (Нотлох баримт 11)<br>Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон бусад улсуудын оюуны өмчийн байгууллагаас зохион байгуулсан зайны болон бусад сургалт, хурал зөвлөгөөнд нийт давхардсан тоогоор нийт 36 албан хаагчид оролцсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | (Нотлох баримт 12, хуудасны тоо 2). | |
| 8 | | 3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд: | 2018 - 2022 | | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36387 албан хаагчийг сургалтад хамруулсан байх | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан тушаалтан болон бусад албан хаагчид 100 хувь сургалтанд хамрагдсан.<br><br>2019 онд тус газрын албан тушаалтан болон бусад албан хаагчдад буюу давхардсан тоогоор нийт 50 албан хаагчид (Нотлох баримт 13, хуудасны тоо 5) дараах сургалтанд хамрагдсан байна. Үүнд:<br><br>1.АТГ, Төрийн албаны ёс зүй сургалт<br><br>2.АТГ, Авлигын эсрэг сургалт<br><br>3.АТГ, ЗГХЭГ, Иргэдийн өргөдөл, гомдол: шийдвэрлэлт, хяналт, тайлагналт төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудын форум<br><br>4. АТГ, ХХМТГ, Транспэрэнси Интернейшнл, Авлигын эсрэг чуулган 2019<br><br>5. Дотоод сургалт, Эрх бүхий албан тушаалтнаас анх төрийн албанд томилогдсон албан хаагчдад Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг ухамсарлах чиглэлээр сургалт<br><br>6. Дотоод сургалт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, 2019 оны ХАСХОМ мэдүүлэх болон холбогдох асуудлаарх сургалт<br><br>Тайлангийн хугацаанд авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журам, анхаарах зүйлийн талаар мэдээлэх, танилцуулах, арга зүйн зөвлөгөө үзүүлэх ажлуудыг тухай бүр хийж хэрэгжүүлсэн бөгөөд ХАСХОМ хугацаанд нь бүрдүүлэн, холбогдох тайлан мэдээг цаг тухай бүр гаргаж, хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Урьдчилан мэдүүлэг бүрдүүлэх, ХАСХОМ бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллүүдийг Able системээр түгээж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан.<br><br>Тус газрын 2019 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, төвөлгөөг болон 2019 онд авлигын эсрэг сургалтанд хамрагдсан албан хаагчдын судалгааг цахим хуудсанд байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан болно.<br><br>(Нотлох баримт 14, хуудасны тоо 9) | |
| 2. Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 9 | 4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах | 2017 - 2018 | | Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчилсэн байх | Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын E-filing, IPOM Publish системийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын төслийн хүрээнд хөгжүүлж, ашиглалтанд оруулсан. Энэхүү төслийн хүрээнд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг хязгаарлагдмал хүрээнд онлайнаар мэдүүлэх боломжтой болсон ба хөгжүүлэлтийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын тусламжтай хийдэг. Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын дотоод системийг /IPAS/ байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br><br>Нотлох баримт: https://publish.ipom.mn/wopublish-search/public/home;jsessionid=729977C64AAAB4D1A0B974D576EF95C4?0<br><br>https://efiling.ipom.mn/efiling/ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | | 2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 2018 - 2022 | | Төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайтыг боловсронгуй болгосон байх | Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын E-filing, IPOM Publish системийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын төслийн хүрээнд хөгжүүлж, ашиглалтад оруулж, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа болно.<br><br>Нотлох баримт: https://publish.ipom.mn/wopublish-search/public/home;jsessionid=729977C64AAAB4D1A0B974D576EF95C4?0<br><br>https://efiling.ipom.mn/efiling/ | 100% |
| 11 | 4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2018 - 2022 | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх зөвшөөрлийг тодорхойлсон байх | Оюуны өмчийн газраас төрийн бус байгууллагад чиг үүрэг шилжүүлж ажиллаагүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 12 | 4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод | 3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт | 2018 - 2022 | | Хяналтын шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор | Тухайн жилд явуулсан хяналт шалгалтын үйл ажиллагаа болон хяналт шалгалтын үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан болно.<br><br>(Нотлох баримт 15, хуудасны тоо 2) | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | шалгалтын чиглэлийг цөөрүүлэх | | | зохион байгуулдаг болсон байх | Оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, хяналт шалгалтын чиглэлээр Оюуны өмчийн газар, “Нарантуул” олон улсын худалдааны төв хамтран “Оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр, “Барааны тэмдгийн зөрчлөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, Гаалийн ерөнхий газрын байцаагч нарт давтан сургалтыг “Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг гаалийн байгууллага ялган таних, шалгах, саатуулах” үйл ажиллагаатай холбогдуулан Оюуны өмчийн эрхийг хамгаалах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа сэдэвт сургалт гэх мэт 70 гаруй сургалт, уулзалтыг зохион байгуулж, Кино уран бүтээлийг хамгаалах холбоотой хамтран Оюуны өмчийн хулгай бол гэмт хэрэг сэдэвтэй 2 видео шторкийг телевиз болон сайтаар дамжуулан хүргэсэн гэх мэт ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.<br>(Нотлох баримт 10, хуудасны тоо 20) | |
| 13 | 4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | 2017 - 2022 | | ТББ, мэргэжлийн холбоо, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар 2 жил тутамд үнэлгээ | Авлигатай тэмцэх газраас 2019 онд хэрэгжүүлсэн байгууллагын шударга байдлын үнэлгээнд Оюуны өмчийн газар хамрагдан шударга байдлын үнэлгээгээр 81.6 үнэлэгдэж, өмнөх оны үзүүлэлттэй /2018 онд Оюуны өмчийн газар 76.1 үнэлгээ авч 9 дүгээрт эрэмбэлэгдсэн/ харьцуулахад 5.5 хувиар өсөж 5 дугаарт эрэмбэлэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | | | | хийлгэсэн байх | https://iaac.mn/news/shudarga-baidliin-unelgee<br><br>(Нотлох баримт 16) | |
| 14 | | 2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх | 2018 - 2019 | | Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгдөг болсон байх | Оюуны өмчийн газарт 2018 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгын судалгаанаас оюуны өмчийн газрын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандаагүй болно.<br><br>(Нотлох баримт 4) | 100% |
| 3. Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 15 | 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах | 2017 - 2019 | | Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх | Оюуны өмчийн газрын 2019 оны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн мэдээлэл гэх мэт холбогдох үйл ажиллагааны шилэн дансыг хөтөлж, цахим хуудаснаас шууд шилэн дансны сайтад нэвтрэхээр холбож, олон нийтэд мэдээлж ажилласан.<br><br>https://www.shilendans.gov.mn/org/9563?group=2&year=2019<br><br>(Нотлох баримт 17, хуудасны тоо 2) | 100% |
| 16 | | 2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах | 2017 - 2020 | 360,0 | Тусгай сангийн хөрөнгийг зарцуулах | 1.Оюуны өмчийн газар нь өөрийн хөрөнгөөр Нээлттэй цахим тендер шалгаруулалтын журмаар “Сервер, тоног төхөөрөмж”, “Зохиогчийн эрхийн програм хангамж” | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх | | | шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх | болон “Авто тээврийн хэрэгслийн тендер”, Тендер шалгаруулалтын онцгой журам, Харьцуулалтын аргаар Шатахууны гэсэн 4 тендерийг зарласан байх бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, оюуны өмчийн газрын цахим хуудсаар нийтэд мэдээлж ажилласан.<br>“Эдийн засгийн шуудан” сонины 2019.03.26-ны №057,058 дугаарт Суудлын автомашин болон бага оврын микро автобус нийлүүлэгчийг сонгох тендерийн урилга, “Өдрийн сонин” 2019.10.21-ны №215 дугаарт Оюуны өмчийн газрын тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх тендерийн урилгыг тус тус нийтлүүлсэн байна.<br>Тендерийг нийтэд зарлахдаа байгууллагын цахим хуудсанд худалдан авах ажиллагааны ил тод байдлын хэсэгт тендерийн нэрээр байршуулж, https://www.tender.gov.mn/ -тай холбож мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.<br>(Нотлох баримт 18, хуудасны тоо 3) | |
| 17 | 4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах | 2017 - 2022 | | Орон нутгийн төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх нөхцөл бүрдсэн байх | - | Үнэлэх боломжгүй |
| 18 | | 2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын | 2018 - 2022 | | Цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд | - | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | | | санал авах мэдээллийг хүргэж хэвшсэн байх | | |
| 19 | 4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | 2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2019 | | Журмыг батлуулж, хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлсэн байх | - | Үнэлэх боломжгүй |
| 6. Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | | | | |
| 20 | 4.1.6.2. Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн | 1. Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | 2017 - 2019 | | Сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн байх | Оюуны өмчийн газар 2019 оныг Мэдээлэл, сурталчилгааны жил болгож зарлаж, улмаар тухайн онд нийт 70 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулж оюуны өмчийн мэдлэгийг олон нийтэд түгээж ажилласан байна. Үүнд:<br>-Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын талаарх ерөнхий ойлголтыг түгээх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 14 аймагт тухайлбал Орхон, Сэлэнгэ, Эрдэнэт, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Баянхонгор аймгуудын иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан оюуны өмчийг өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талаар "Оюуны өмчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | заагийг тодорхойлох | | | | | эрхийн хамгаалалт” сэдвээр сургалт;<br><br>-Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулгыг оюуны өмчийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоод, хамтын удирдлагын байгууллага, төрийн бус байгууллага болон иргэдэд 5 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт.<br><br>-Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, хяналт шалгалтын чиглэлээр 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Оюуны өмчийн газар, “Нарантуул” олон улсын худалдааны төв хамтран “Оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хэлэлцүүлэг,<br><br>-Иргэд, аж ахуй нэгжийн хүсэлтээр Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн дэргэдэх “Улаанбаатар инновацийн төв”-ийн инкубаторт бойжиж буй гарааны компаниудад оюуны өмчийн эрхийн хамгаалалтын талаар сургалт,<br><br>-Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах төсөлд хамрагдаж буй жижиг дунд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Барааны тэмдэг газар зүйн заалт болон бүтээгдэхүүний загварын талаар гэх мэт сургалтуудыг зохион байгуулсан.<br><br>(Нотлох баримт 10, хуудасны тоо 20) | |
| 21 | 4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг | 4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр | 2018 - 2020 | | Хөтөлбөрийг төслийг боловсруулж, | Патентын тухай хууль болон Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, Газарзүйн заалтын тухай хуульд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах | хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | | | батлуулсан байх | нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн. | |
| 7. Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих | | | | | | | |
| 22 | 4.1.7.2. Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох чиглэлээр төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох | 2. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх | 2019 - 2020 | | Эрх зүйн зохицуулалт бий болгосон байх | Оюуны өмчийн газар нь дараахь субьектэд тусгай зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж ажилладаг. Үүнд:<br>1. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид Патентын тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу Оюуны өмчийн газар нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг баталж, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрөл олгодог.<br>Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын төлөөллийн үйл ажиллагааны тайланг Оюуны өмчийн газарт ирүүлэх бөгөөд үйлчилгээний хөлсний 10%-ийг Оюуны өмчийн газарт өгөхөөр Патентын тухай хуульд заасан.<br>https://www.legalinfo.mn/law/details/440?lawid=440<br>2.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.Зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид эрхээ хамгаалуулах зорилгоор, хамтын удирдлагын байгууллагыг байгуулан ажиллуулж болно, 27.4.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана гэж тус тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | заасныаас гадна 29.1.1.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны шагналыг олгохдоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах үүрэгтэй.<br><br>https://www.legalinfo.mn/law/details/283 | |
| 23 | 4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | 1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх | 2017 - 2019 | | Хяналт тавих боломж бүрдсэн байх | https://www.ipom.gov.mn/ цахим хуудсаар дамжуулан байгууллагын үйл ажиллагаа, авлигын эсрэг үйл ажиллагаа, хүний нөөц, шилэн данс болон оюуны өмчийн газрын даргын тушаал, хууль эрх зүйн болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан болно. | Үнэлэх боломжгүй |
| 24 | | 2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх | 2018 - 2022 | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан байх | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ажиллаагүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 10. Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| боловсролыг дээшлүүлэх | | | | | | | |
| 25 | 4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах | 2017 - 2022 | | Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх | Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлсэн байгууллагын шударга байдлын үнэлгээнд Оюуны өмчийн газар хамрагдсан.<br>2019 оны шударга байдлын үнэлгээгээр 81.6 үнэлэгдэж, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 5.5 хувиар өсөж 5 дугаарт эрэмбэлэгдсэн байна.<br>Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд Оюуны өмчийн газар 76.1 үнэлгээ авч 9 дүгээрт эрэмбэлэгдсэн.<br>https://iaac.mn/news/shudarga-baidliin-unelgee<br>(Нотлох баримт 16) | 100% |
| 26 | 4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | 2017 - 2022 | | Аймаг, нийслэлд 100 сургагч багшийг бэлтгэсэн байх | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанг холбогдох гарын авлага, ном сурах бичгээр хангаж, холбогдох хууль журамд нийцүүлэн ажиллах боломжоор хангаж ажиллаж байна. | Үнэлэх боломжгүй |